

2023 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм”-ийн 8 дугаар зүйлийн 8.11.20 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Худалдаа, хөгжлийн банк болон Ти Ди Би Лизинг ХХК нарын хооронд байгуулсан 2013 оны 09-р сарын 23-ны өдрийн №А/198 тоот Эх үүсвэргүй аккредитив, баталгааны эрх нээх гэрээ болон №ЗЭГ/198 тоот Зээлийн эрх нээх гэрээнүүдийн нөхцөлд өөрчлөлт оруулж, Ти Ди Би Лизинг ХХК-тай энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлтэй Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ, Эх үүсвэргүй аккредитив, баталгааны эрх нээх нэмэлт гэрээнүүдийг байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ, хэлцэл болон холбогдох бусад баримт бичигт Худалдаа, хөгжлийн банкныг төлөөлөн гарын үсэг зурах, холбогдох этгээдэд дамжуулан итгэмжлэл олгох болон шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОППА

Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 10 дугаар сарын 9-ны өдрийн 59 тоот тогтоолын хавсралт

Зээлийн эрх нээх нэмэлт гэрээний нөхцөл

№	Гэрээний нэр	Зээлийн эрхийн дүн	Зээлийн хүү/жилээр/
1	Зээлийн эрх нээх нэмэлт гэрээ	24,000,000,000.00 (хорин дөрвөн тэрбум) төгрөг байх ба үүнээс 2,000,000,000.00(хоёр тэрбум) төгрөг болон түүнтэй тэнцэх хэмжээний ам.доллар, евро, иен болон юаний зээлийн эрхийн дүнд банк үүрэг хүлээнэ.	16.00% - MNT 12.10% - USD, EUR, CNY, JPY
2	Эх үүсвэргүй аккредитив, баталгааны эрх нээх нэмэлт гэрээ	24,000,000,000.00 (хорин дөрвөн тэрбум) төгрөг байх ба үүнээс 2,000,000,000.00(хоёр тэрбум) төгрөг болон түүнтэй тэнцэх хэмжээний ам.доллар, евро, иен болон юаний зээлийн эрхийн дүнд банк үүрэг хүлээнэ.	